



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/387

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 04, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Оргил багийн дахин төлөвлөлт хийх 1,2 дугаар байр, урчуудын 4 айл, 23 дугаар байрнуудын үнэлгээ хийх ажлыг "Далайван проперти үнэлгээ" ХХК -тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Насанбат)-д олгосугай.

2.Шаардагдах 19,980,000 (арван есөн сая есөн зуун наян мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Насанбат)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (А.Алтанхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ